

<http://www.mod.gov.mn/index.php?com=news&id=1295>

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД АВСТРАЛИ УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД ЖОН ЛАНГТРИГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

2016 оны 10 сарын 07 | enkhtuvshin



Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ, Австрали Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Жон Лангтриг Төрийн ордонд хүлээн авч уулзлаа.

Уулзалтад Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, бригадын генерал Ч.Сосорбарам, Австрали Улсаас хүрэлцэн ирж хоёр орны Батлан хамгаалах бодлогын яриа хэлцэл хийж байгаа хатагтай Сара Фарнхам тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо. Монгол Улс, Австрали Улсын хооронд 1972 оны 9 дүгээр сарын 15-нд дипломат харилцаа тогтоосон бөгөөд ирэх жил 45 жилийн ойг тэмдэглэнэ. Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд хоёр орны харилцаа нь улс төр, худалдаа, эдийн засаг, боловсрол, хүмүүнлэгийн салбарт амжилттай хөгжиж ирсэн төдийгүй хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байна.

2013 оноос Сөүл хотод суугаа Батлан хамгаалахын атташе харилцан хавсран суух болсноор хамтын ажиллагаа өргөжих боломжтой болж, тохиролцсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд батлан хамгаалахын атташе нарын гүйцэтгэх үүрэг улам өндөр болж байгааг Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ уулзалтын эхэнд онцлон тэмдэглэв. Харилцааг цаашид гүнзгийрүүлэн шинэ шатанд гаргахад хоёр тал "Харилцан ойлголцлын санамж бичиг"-т гарын үсэг зурсан явдал онцгой үйл явдал болсон. Санамж бичгийн хүрээнд батлан

хамгаалах салбарын холбогдолтой туршлага болон мэдээлэл солилцох журмаар энэ удаагийн Батлан хамгаалах яриа хэлцэл явагдаж байгаа юм.

Хамтын ажиллагааны хүрээнд батлан хамгаалах яриа хэлцлийг амжилттай зохион байгуулсан, Австралийн Зэвсэгт хүчний Команд штабын коллежид Монголын 2 дахь офицер суралцаж байгаагийн зэрэгцээ Монгол Улсад жил бүр зохион байгуулдаг "Хааны эрэлд" энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургуульд Австрали Улс нь цэргийн алба хаагчдаа 2008 оноос хойш тогтмол оролцуулж ирсэн нь хоёр орны Батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагаа амжилттай хэрэгжиж байгаагийн илрэл болохыг УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ уулзалтын явцад дурдлаа. Австрали Улсын Элчин сайд Жон Лангтри цаашид Австралийн талаас "Хааны эрэлд" сургуульд оролцох оролцоогоо хадгалахын зэрэгцээ ойрын 2-3 жилд Австрали Улсын Цэргийн сургуульд Монгол Улсаас сонсогч, оюутан суралцах боломжийг эрэлхийлж байгаа болон цэргийн боловсрол, сургалтын хүрээнд Монгол Улсаас Австрали Улсад суралцах цэргийн алба хаагчдын тоог нэмэгдүүлэх боломжтойг дурдаад Монгол Улс нь Австрали Улсын хувьд идэвхтэй харилцагч, хамтрагч түнш орон болохыг тэмдэглэв.